

## **ҮНИЙН САНАЛ УРИЛГЫН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалтын нэр: Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хяналт тохируулгын анализатор нийлүүлэх

Тендер шалгаруулалтын №: G18

Тендер шалгаруулалтын арга: Харьцуулалт

Төслийн нэр: “Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төсөл

Санхүүжүүлэгч: Дэлхийн банкны зээл, Төсөл № P173779, 100 хувь санхүүжүүлнэ

## ҮНИЙН САНАЛЫН УРИЛГА

Тендер шалгаруулалтын нэр:	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хяналт тохируулгын анализатор нийлүүлэх
Тендер шалгаруулалтын №:	G18
Тендер шалгаруулалтын арга:	Харьцуулалт – бараа
Төслийн нэр:	“Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төсөл
Санхүүжүүлэгч:	Дэлхийн банкны зээл, Төсөл № P173779, 100 хувь санхүүжүүлнэ.
Урилгын огноо:	2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр

1. Эрүүл мэндийн яам нь Дэлхийн банкны санхүүжилттэй “Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн хүрээнд, эрх бүхий хуулийн этгээдийг “G18 - Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хяналт тохируулгын анализатор нийлүүлэх” тухай битүүмжилсэн үнийн санал ирүүлэхийг урьж байна. Дараах үндсэн тоног төхөөрөмжийг энэ үнийн саналын урилгад хамруулсан:

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хяналт тохируулгын анализатор нийлүүлэх:

Gas-flow analyzer, Хийн урсгалын анализатор – 2 иж бүрдэл

X-ray test device, Рентген цацрагийн чанарын хяналтын анализатор – 1 иж бүрдэл

Incubator analyzer, Нярайн инкубаторын анализатор – 2 иж бүрдэл

Electrosurgery analyzer, Цахилгаан мэс заслын аппаратын анализатор – 2 иж бүрдэл

Ultrasound phantom, Хэт авиан оношилгооны аппаратны фантом – 2 иж бүрдэл

Laptops, Зөөврийн компьютер – 5 иж бүрдэл

2. Сонирхсон этгээд нь [baasanbayar@ehp.mn](mailto:baasanbayar@ehp.mn) имэйлээр хандан бичгээр хүсэлтээ гаргаж, 50,000 төгрөгийн эргэн үл төлөгдөх хураамжийг төлсөнөөр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй болно. Төлбөрийг доорх дансанд шилжүүлнэ /төлбөрийн даалгавар дээр тендер шалгаруулалтын дугаарыг заавал бичнэ/.

Хүлээн авагчийн банк: Төрийн сангийн банк

Төгрөгийн данс: 100900011981

Дансны нэр: Ковид-19-с УСХАХАББХТөсөл

3. Хураамжаа төлсөн этгээдэд Монгол хэл дээр үйлдсэн Үнийн саналын урилгын баримт бичгийг имэйлээр илгээнэ.

4. Энэ харьцуулалтын аргаар явуулах тендер шалгаруулалтыг Дэлхийн банкны “Procurement Regulations for IPF Borrowers” November 2020 edition (“Procurement Regulations”) худалдан авалтын журмын дагуу хэрэгжүүлнэ.

5. Дотоодын давуу эрхийн зөрүү тооцохгүй.

6. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

7. Уг тендер шалгаруулалт нь багцгүй болно.

8. Сонирхсон этгээд нь зөвхөн нэг үнийн санал ирүүлнэ. Хувилбарт үнэтэй үнийн саналаас захиалагч татгалзана. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгөөр ирсэн үнийн саналаас татгалзана.

9. Таны үнийн санал нь принтерээр хэвлэгдсэн, эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамгатай байна. Үнийн саналын маягтад гарын үсэг зурж, тамга дараагүй бол үнэлгээнд харгалзахгүй. Үнийн саналыг 1 эх хувиар ирүүлнэ.

10. Тендерийн баталгаа ирүүлэх шаардлагагүй. Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.

11. Танай компани нь дараах чадварын болон бусад шалгуурыг хангах шаардлагатай:

- (1) Энэ сонгон шалгаруулалтын зураг төсөл, техникийн тодорхойлолтыг зохиосон хувь хүн, хуулийн этгээдтэй нэгдмэл сонирхолтой этгээд биш байх. Энэ талаар үнийн саналын маягтад зааж ирүүлнэ.
- (2) Үнийн санал нь түүнийг нээснээс хойш **30** ба түүнээс дээш хоногийн хугацаанд хүчинтэй байх. Энэ талаар үнийн саналын маягтад заана.
- (3) Графикт заасан хугацаанд барааг нийлүүлсэн байх: Гэрээний барааг гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш хуанлийн **90** хоногт багтаан эцсийн хэрэглэгчид хүлээлгэн өгсөн байна.
- (4) Тусгай зөвшөөрөлтэй байх. Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж худалдах импортлох, ханган нийлүүлэх, худалдах хуулбарыг үнийн саналын хамт ирүүлэх шаардлагатай.
- (5) Үйлдвэрлэгчийн зөвшөөрөлтэй байх. Тоног төхөөрөмжийн нэр зүйл бүрээр Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл эсвэл албан ёсны төлөөлөгч болохыг нотолсон баримт бичгийг үнийн саналын хамт ирүүлнэ.
- (6) Эмнэлгийн тоног төхөөрөмжийн 1-ээс доошгүй инженертэй байх: инженерийн чадвар, боловсрол, ажлын туршлагыг харуулсан намтар, мэргэжлийг илтгэх боловсролын диплом, үнэмлэхний хуулбарыг ирүүлнэ. “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер” гэдэгт тус мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш түвшний боловсрол эзэмшсэн хүнийг хэлнэ.
- (7) Монгол Улсын хуулийн дагуу төлөх татвар, хураамжийн хувьд үнийн санал нээсэн өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн өргүй байна. Холбогдох тодорхойлолтыг үнийн саналын хамт ирүүлнэ.
- (8) Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **182,600,000** төгрөгөөс багагүй байх бөгөөд харилцагч банкны дансны үлдэгдлийн тодорхойлолт, шугаман зээлийн эрхийн үлдэгдлийн тодорхойлолтоор тооцно. Судлан үзэх болон шалгарсан тохиолдолд олгох боломжтой тухай тодорхойлолтыг тооцохгүй.
- (9) Борлуулалтын орлогын жилийн дундаж хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2022, 2023 оны дундаж борлуулалтын хэмжээ нь **1,217,400,000** төгрөгөөс багагүй байна. 2022, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг ирүүлнэ.
- (10) Ижил төстэй ажлын туршлага: 2022, 2023 оны хугацаанд эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн доод тал нь 1 гэрээтэй байх, нийт гэрээний үнийн дүн нь **304,300,000** төгрөгөөс багагүй байх. Гэрээний хуулбарыг, захиалагчийн хүлээн авах актын хамт ирүүлнэ. “Ижил

төстэй гэрээ” гэдэгт Эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн гэрээг ойлгоно.

- (11) Санал болгосон тоног төхөөрөмж нь үнийн хуваарьт заасан захиалагчийн техникийн тодорхойлолтыг биелүүлсэн байх. Үнийн хуваарийг бөглөх, тоног төхөөрөмж шаардлагад нийцсэн болохыг нотлон харуулах танилцуулга, каталог, гарын авлага, стандартын гэрчилгээг ирүүлнэ. Хэрэв тендерт оролцогч нь захиалагчийн шаардсан техникийн үзүүлэлтээс бага зэрэг зөрсөн, гэхдээ үндсэндээ ижил тоног төхөөрөмж, багаж санал болгосон ба энэ тоног төхөөрөмж, багаж нь шаардсан техникийн үзүүлэлтийн чиг үүргийг гүйцэтгэж чадна хэмээн Захиалагч үзвэл, тухайн барааг шаардлагад нийцсэн хэмээн Захиалагч хүлээн зөвшөөрнө. Хэтрүүлэн биелүүлсэн техникийн үзүүлэлт бүхий тоног төхөөрөмж санал болгосон үнийн саналыг үнэлгээнд давуу эрхтэйгээр авч үзэхгүй.
- (12) Тендерт оролцогч нь Хуулийн этгээдийн өмчлөгчийн тухай мэдээллийг Үнийн санал авах баримт бичгийн маягтын дагуу ирүүлнэ.

12. Тендерт оролцогчийн тендерийн материал бэлтгэх хэл: Монгол хэл байна. Санал болгож буй тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, танилцуулга, каталог, гарын авлага, чанарын болон нийцлийн стандартын гэрчилгээ зэрэг нь Англи хэл дээр байж болно, эдгээрийн монгол хэл дээрх албан ёсны орчуулгын хамт ирүүлнэ.

13. Нэмэлт мэдээлэл: Тендерт оролцогч нь тендер ирүүлэхийн тулд <https://www.tender.gov.mn/> сайтаар бүртгүүлэхгүй. Тендерийг уламжлалт аргаар буюу цаасаар, битүүмжилсэн хэлбэрээр Үнийн санал авах баримт бичигт заасны дагуу ирүүлнэ. Тендерт оролцогчоос ирүүлсэн тодруулгын хүсэлтийн хариуг захиалагч нь тендерийн баримт бичиг худалдан авсан компаниудад бүртгэлтэй мэйл хаягаар нь илгээнэ. Шүүхийн төрөлжсөн архив, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолтыг үнийн саналын хамт ирүүлнэ.

14. Захиалагч нь үнийн санал ирүүлэх эцсийн хугацаа дуусахаас арван (10) хоногийн өмнө хүлээн авсан тодруулга хүссэн аливаа хүсэлтэд бичгээр хариу өгнө. Энэ өдрөөс хойш хожимдсон тодруулга авах хүсэлтийг хүлээн авахгүй. Энэхүү үнийн саналын урилгын баримт бичигтэй холбоотой тодруулга авах хүсэлтийг [baasanbayar@ehp.mn](mailto:baasanbayar@ehp.mn) хаягаар хүргүүлнэ. Тодруулгыг тендерийн баримт бичиг худалдан авсан бүх этгээдэд имэйлээр хүргэнэ.

15. “Дэлхийн банкны Зээлдэгчдэд зориулсан худалдан авах ажиллагааны журам”-ын 3.21-3.25 (Тендерт оролцох эрх, Худалдан авалтын зөрчил), 3.32 (Авлига, хээл хахууль) болон 5.94 (Гэрээ байгуулах эрх олгох) дугаар зүйлд заасан холбогдох шаардлагыг хангасан байна. Дэлхийн банкны дээр дурдагдсан заалтуудтай <http://pubdocs.worldbank.org/en/178331533065871195/Procurement-Regulations.pdf> холбоосоор орж танилцсан байх шаардлагатай.

16. Үнийн санал ирүүлэх: Үнийн саналыг хавсралт № 1-д заасан маягт болон энэхүү үнийн саналын урилгын баримт бичгийн дагуу ирүүлнэ. Үнийн санал хүлээн авах эцсийн хугацаа нь: **2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 16:00 цаг /Улаанбаатарын цагаар/ болно.** Энэ хугацаанаас хоцорч ирсэн үнийн саналыг хүлээн авахгүй. Үнийн санал ирүүлэх хаягийг доор заасан болно.

17. Үнийн санал нээх: Ирүүлсэн үнийн саналыг үнийн санал хүлээн авах эцсийн хугацаа дууссаны дараа оролцогчдын төлөөллийг байлцуулан дээр дурдсан хаягт шууд нээнэ.

18. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ: Гэрээ байгуулах эрхийг дараах шаардлагыг хангасан оролцогчид олгоно.

- i) Чадварын шаардлагад нийцсэн
- ii) Техникийн шаардлагад нийцсэн
- iii) Нийлүүлэлтийн хуваарийн шаардлагад нийцсэн
- iv) Хамгийн бага үнэ санал болгосон

19. Дэлхийн банк нь Хуваарь № 1-д заасан “Авлигатай тэмцэх журам”-ыг биелүүлэхийг шаардана.

Дэлхийн банкны төсөл хэрэгжүүлэх нэгж

Хаяг: УБ, СБД, 1-р хороо, Олимп 5, Аюуд тауэр, 11-р давхар, 1103 тоот  
Утасны дугаар: 7707-7793, Цахим шуудангийн хаяг: [baasanbayar@ehp.mn](mailto:baasanbayar@ehp.mn)

**Хавсралт № 1: Үнийн саналын маягт**  
**Хавсралт № 2: Гэрээний маягт**  
**Хуваарь № А: Авлигатай тэмцэх журам**  
**Гүйцэтгэлийн баталгааны маягт (Банкны)**

## Хавсралт № 1: Үнийн саналын маягт ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМАНД

1. Бид, G18 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хяналт тохируулгын анализатор нийлүүлэх ажлыг \_\_\_\_\_ (тендерийн үнийг тоогоор болон үсгээр) тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна. Үнийг гэрээний хэрэгжилтийн хугацаанд тохируулахгүй. Үнэд дараах татвараас бусад татварыг тооцож оруулсан: (1) гаалийн импортын үед тоног төхөөрөмж, бараанд оногдуулдаг НӨАТ, гаалийн татвар, (2) захиалагчаас нийлүүлэгчид гэрээний дагуу шилжүүлэх дотоодын гүйлгээнд тооцдог НӨАТ.

Тайлбар: гадаад худалдааны гэрээ, эсхүл үнийн нэхэмжлэх, тээврийн баримт бичиг, гаалийн үнийг тодорхойлоход шаардлагатай бусад баримт бичиг зэргийг Захиалагчид хүлээлгэн өгснөөс хойш ажлын 10 хоногийн хугацаанд гаалийн баталгаат агуулах, талбайд бараа хадгалах зардлыг Үнийн саналд тооцож шингээсэн.

2. Гэрээний төлбөрийг төгрөгөөр хийх болон Үнийн саналын үнэ нь Гэрээний хэрэгжилтийн хугацаанд тогтмол байхыг бид хүлээн зөвшөөрч байна.
3. Үнийн санал нь үнийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ..... хоногийн хугацаанд хүчинтэй.
4. [Аль нэг хувилбарыг сонгох: үнийн хөнгөлөлт санал болгох бол тооцох аргачлал, хувь, дүнг тодорхой бичих, Бид үнийн хөнгөлөлт санал болгоогүй. Бид дараах үнийн хөнгөлөлт санал болгож байна.]
5. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно. Таны хамгийн бага үнэтэй болон аль ч үнийн саналыг заавал шалгаруулах үүрэггүй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.
6. Тус компани нь энэ сонгон шалгаруулалтын зураг төсөл, техникийн тодорхойлолтыг зохиосон хувь хүн, хуулийн этгээдтэй нэгдмэл сонирхолтой этгээд [мөн, биш – аль нэгийг сонгох] болно.
7. Бид гэрээний маягт, гэрээний нөхцөл болзолыг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
8. Бидний тендер шалгарсан тохиолдолд гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулж гэрээний үнийн дүнгийн ..... хувьтай тэнцэх гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхээ амлаж байна.
9. Бид болон гэрээний гүйцэтгэлд оролцох аливаа туслан гүйцэтгэгч, бэлтгэн нийлүүлэгч, зөвлөх, үйлдвэрлэгч, үйлчилгээ үзүүлэгч нь Дэлхийн банкны группийн гишүүн эсвэл Дэлхийн банк болон бусад хөгжлийн банкуудын хооронд байгуулсан Тендер шалгаруулалтын шийдвэрийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай харилцан ойлголцлын санамж бичигт заасны дагуу түр хугацаагаар түдгэлзүүлсэн эсвэл хар жагсаалтад орсон байгууллага болон хувь хүнтэй холбоогүй бөгөөд удирдлагад нь ажилладаггүй болно. Түүнчлэн

Захиалагчийн орны хууль тогтоомж эсвэл НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийн дагуу эсвэл албан журамд үл нийцсэн биш болно.

10. Бид Дэлхийн банкны худалдан авах ажиллагааны 3.21-3.25, 3.32 заалтуудын дагуу Захиалагчтай ямарваа нэгэн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгийг мэдэгдэж байгаа бөгөөд энэхүү тендер шалгаруулалттай холбоотой баримт бичиг, материалыг Дэлхийн банкнаас томилон бие даасан аудитораар хянуулахад татгалзах зүйлгүй болно.
11. Манай компани нь Дэлхийн банкны хоригийн жагсаалтад ороогүй.
12. Маягт № 1, 2, 3, 4-ийг бэлтгэж хавсаргав.
13. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь:

Барааны нэр, тоо	Барааг хүргэх эцсийн цэг	Нийлүүлэх эцсийн хугацаа – Захиалагчийн шаардлага	Тендерт оролцогчийн санал болгосон хугацаа
Gas-flow analyzer, Хийн урсгалын анализатор – 2 иж бүрдэл	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар UBH center, Энхтайваны өргөн чөлөө, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Улаанбаатар, Mongolia	Гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш хуанлийн 90 хоногт багтаан барааг эцсийн цэгт хүргэсэн байх шаардлагатай	
X-ray test device, Рентген цацрагийн чанарын хяналтын анализатор – 1 иж бүрдэл			
Incubator analyzer, Нярайн инкубаторын анализатор – 2 иж бүрдэл			
Electrosurgery analyzer, Цахилгаан мэс заслын аппаратын анализатор – 2 иж бүрдэл			
Ultrasound phantom, Хэт авиан оношилгооны аппаратны фантом – 2 иж бүрдэл			
Laptops, Зөөврийн компьютер – 5 иж бүрдэл			

*[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг, хаяг, утасны дугаар, имэйл хаяг]:*

### МАЯГТ № 1 - ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл бараа хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/ факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

*[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг, хаяг, утасны дугаар, имэйл хаяг]:*

### МАЯГТ № 3 - ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ЗӨВШӨӨРӨЛ

[Тайлбар: Энд дурдсан зааврын дагуу үйлдвэрлэгч энэ маягтыг бөглөнө. Энэхүү зөвшөөрлийг үйлдвэрлэгчийн албан бланк дээр бичиж, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурсан байна. Энэ зөвшөөрлийн агуулгатай ижил төрлийн бусад зөвшөөрлийг шаардлагад нийцсэнд тооцно, жишээлбэл борлуулагч, дилер, дистрибьютер, засвар үйлчилгээний зөвшөөрөл гэх мэт.]

Огноо: .....

ТШ-ын дугаар: **[оруул: тендер шалгаруулалтын дугаар]**

(Захиалагчийн нэр)-ын дарга \_\_\_\_\_Танаа

Бид, *[үйлдвэрлэгчийн бүтэн хаягийг оруулах]*-д байршилтай *[үйлдвэрлэгчийн бүрэн нэрийг оруулах]* нь *[үйлдвэрлэдэг/борлуулдаг барааны төрлийг оруулах]*-ийг албан ёсоор үйлдвэрлэдэг/борлуулдаг бөгөөд үүгээр *[тендерт оролцогчийн бүтэн нэрийг оруулах]* компанид бидний үйлдвэрлэсэн/борлуулсан *[оруул: барааны нэр ба товч тодорхойлолт]* барааг санал болгосон тендер ирүүлж, улмаар хэлэлцээр хийж гэрээ байгуулахыг зөвшөөрч байна.

Бид дээр дурдсан компанийн санал болгосон барааны хувьд Үнийн хуваарьт заасан чанарын баталгааг бүрэн гаргаж байна.

Үйлдвэрлэгчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Нэр ба албан тушаал:

Гарын үсэг зурсан огноо:

Хаяг:

## МАЯГТ № 4 - ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ӨМЧЛӨГЧИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

*Тендерт оролцогч, нийлүүлэгчид өгөх заавар: энэ маягтыг бөглөөд энэ зааврыг устгана уу*

*Энэ маягтыг бүх тендерт оролцогч бөглөж тендерийн хамт ирүүлнэ.*

*Шалгарсан тендерт оролцогч нь гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл аваад энэ маягтыг шинэчилж өгнө. Түншлэлийн хувьд, гишүүн бүрээр энэ маягтыг бөглөнө. Энэ маягтад дурдах мэдээлэл нь тендер ирүүлэх үеийн бодит мэдээллийг агуулна.*

*Энэ маягтын хуулийн этгээдийн өмчлөгч гэдэгт дараах нөхцөлийн нэг буюу түүнээс олныг нь хангасан эцсийн хувь хүнийг хэлнэ:*

- Шууд болон шууд бусаар хөрөнгийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг*
- Шууд болон шууд бусаар саналын эрхийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг*
- Шууд болон шууд бусаар тендерт оролцогчийн захирлуудын зөвлөл, түүнтэй жиших удирдах нэгжийн олонхыг томилох эрхтэй*

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМАНД

Тендер шалгаруулалтын нэр:

Тендер шалгаруулалтын №:

Үнийн саналын урилгын дагуу өмчлөгчийн талаарх мэдээллийг доорх байдлаар хүргүүлж байна: *[аль нэг хувилбарыг сонгоно уу]*

Бидний өмчлөлийн мэдээлэл нь дараах болно.

### Хувилбар 1

Өмчлөгчийн нэр	<i>Шууд болон шууд бусаар хөрөнгийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг (Тийм / Үгүй)</i>	<i>Шууд болон шууд бусаар саналын эрхийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг (Тийм / Үгүй)</i>	<i>Шууд болон шууд бусаар нийлүүлэгчийн захирлуудын зөвлөл, түүнтэй жиших удирдах нэгжийн олонхыг томилох эрхтэй (Тийм / Үгүй)</i>
<i>[ургийн овог, овог, нэрийг бүтнээр нь бичих, иргэншил,</i>			

<i>оршин суугаа улсыг бичих</i>			
-------------------------------------	--	--	--

## Хувилбар 2

Доорх нөхцөлийн аль нэг, хэд болон бүгдийг хангасан өмчлөгч байхгүй болохыг бид мэдэгдэж байна:

- Шууд болон шууд бусаар хөрөнгийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг
- Шууд болон шууд бусаар саналын эрхийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг
- Шууд болон шууд бусаар нийлүүлэгчийн захирлуудын зөвлөл, түүнтэй жиших удирдах нэгжийн олонхыг томилох эрхтэй

## Хувилбар 3

Доорх нөхцөлийн аль нэг, хэд болон бүгдийг хангасан өмчлөгчийг тогтоон тодорхойлох боломжгүй болохыг бид мэдэгдэж байна: *[энэ хувилбарыг сонгосон бол, яагаад тодорхойлох боломжгүй талаарх тайлбарыг энд бичнэ]*

- Шууд болон шууд бусаар хөрөнгийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг
- Шууд болон шууд бусаар саналын эрхийн 25 буюу түүнээс дээш хувийг өмчилдөг
- Шууд болон шууд бусаар тендерт оролцогчийн захирлуудын зөвлөл, түүнтэй жиших удирдах нэгжийн олонхыг томилох эрхтэй

Тендерт оролцогчийн нэр: \*[ оноосон нэрийг бүтнээр бичнэ]

*[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,  
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,  
албан тушаал, гарын үсэг,  
байгууллагын тамга, тэмдэг]:*

Огноо: .....

## Хавсралт № 2: Гэрээний маягт

### БАТЛАВ:

**ЗАХИАЛАГЧ:**  
Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]

**НИЙЛҮҮЛЭГЧ:**  
Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]

### ГЭРЭЭНИЙ МАЯГТ

Нэг талаас Эрүүл мэндийн яам (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2024 оны \_\_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь G18 дугаартай Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хяналт тохируулгын анализатор нийлүүлэх ажлыг (цаашид “бараа” гэх) \_\_\_\_\_ [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн үнийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно. Гэрээний үнэд дараах зардлыг шингээгээгүй: (1) гаалийн импортын үед тоног төхөөрөмж, бараанд оногдуулдаг НӨАТ, гаалийн татвар, (2) захиалагчаас нийлүүлэгчид гэрээний дагуу шилжүүлэх дотоодын гүйлгээнд тооцдог НӨАТ. Нийлүүлэгч нь гаалийн тэмдэг дарсан баглаа боодлын жагсаалт, нэхэмжлэх, тээврийн манифест зэргийг Захиалагчид хүлээлгэн өгснөөс хойш ажлын 7 хоногийн хугацаанд гаалийн баталгаат агуулах, талбайд бараа хадгалах зардлыг Гэрээний үнэд тооцож шингээсэн.

3. Захиалагч нь энэ гэрээг “Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” Дэлхийн банкны төслийн хөрөнгөөр 100 хувь санхүүжүүлнэ.

4. Захиалагч гэрээний үнийг нийлүүлэгч барааг бүрэн хүлээлгэж өгсний дараа Нийлүүлэгчийн .... банкны ..... тоот төгрөгийн дансанд шилжүүлнэ.

5. Нийлүүлэгч нь гэрээний нийт барааг ..... оны ..... дугаар сарын ...-ны өдөр буюу түүнээс өмнө эцсийн цэг, хэрэглэгчид хүргэн өгч, хүлээлгэн өгсөн байна.

6. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>1</sup>  
Үнийн санал  
Гэрээний нөхцөл болзол

<sup>1</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

7. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Дээрхийг гэрчилж талууд нь дээр дурдсан он, сар, өдрөөр энэхүү Гэрээг Монгол Улсын хуулийн дагуу байгуулав.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]\_\_\_\_\_

[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

## ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ БОЛЗОЛ БҮЛЭГ

Гэрээний нэр:	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хяналт тохируулгын анализатор нийлүүлэх
Гэрээний дугаар:	G18
Төслийн нэр:	“Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төсөл

1. Техникийн тодорхойлололт, Үнийн хуваарь: хавсаргав.
2. Гэрээний үнэ тогтмол байх: Гэрээний үнэ нь гэрээний хэрэжилтийн хугацаанд үнийн тохируулгын нөхцөлд хамаарахгүй, тогтмол байна.
3. Хэрэглэх хууль: Монгол Улсын хууль.
4. Маргаан шийдвэрлэх: Энэхүү Гэрээнээс үүссэн, эсвэл түүнтэй холбогдон гарсан аливаа маргааныг талууд аль болох хоорондоо харилцах замаар шийдэхийг эрмэлзэнэ. Ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол, маргааныг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.
5. Төлбөр: Гэрээний үнийг захиалагч нь дараах хуваарийн дагуу төлнө:

Хүлээлгэн өгсөн барааны гэрээний үнийн 100 хувьтай тэнцэх дүнг бараа хүлээлгэж өгснөөс хойш 30 хоногийн дотор нэхэмжлэх, зарлагын падаан болон эцсийн хэрэглэгч барааг шалгаж хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө.
6. Гэрээний гүйцэтгэлийн хяналт: Захиалагч нь Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын даргыг, эсхүл түүний томилсон этгээдийг энэ гэрээний Захиалагчийн зохицуулагчаар томилж байна. Зохицуулагч нь Гэрээний хүрээнд хэрэгжих үйл ажиллагааг зохицуулах, тайлан, төлбөрийн нэхэмжлэх хүлээн авах, батлах эрх, үүрэгтэй болно.
7. Чанарын баталгаа, баталгаат засвар: Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь шинэ, урьд өмнө ашиглагдаагүй, гэмтэл согоггүй бөгөөд хамгийн сүүлийн буюу өнөөгийн загварын, техникийн тодорхойлолтод бүрэн нийцсэн орчин үеийн шинэлэг ололтуудыг агуулсан байна. Өөрийн болон туслан гүйцэтгэгчийн бараа нийлүүлэхэд ашиглах бүх материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл зэрэг нь шинэ, сайн чанарын болон зориулалтынх байна гэдгийг нийлүүлэгч баталгаажуулна. Үнийн хуваарьт өөрөөр заагаагүй бол баталгаат засвар нь барааг хүргэж, ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 12 сарын хугацаанд хүчинтэй байна. Хэрэв нийлүүлэгч гэмтэл согог гарсан мэдэгдэл хүлээн аваад чанарын баталгааны дагуу түүнийг арилгахгүй бол захиалагч өөрөө нийлүүлэгчийн зардлаар уг гэмтэл согогийг арилгах эрхтэй. Энэ зүйлд заасны дагуу нийлүүлэгчийн гаргах баталгаа нь гэрээнд заасан захиалагчийн бусад эрх, үйл ажиллагааг хязгаарлахгүй.
8. Гүйцэтгэлийн баталгаа, чанарын баталгаа: Нийлүүлэгч нь гэрээний үнийн 5 хувьтай тэнцэх дүнтэй гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох

тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор захиалагчид өгнө. Нийлүүлэгч гэрээний дагуу барааг нийлүүлснээс хойш 30 хоногийн дотор захиалагч гүйцэтгэлийн баталгааг хүчингүй болгоно. Эцсийн хэрэглэгчийн хүлээн авсан тухай акт гарахад Гүйцэтгэлийн баталгааны дүнг 50% буруулж, тус баталгааг 12 сарын хугацаанд хүчинтэй байлгана.

9. Алданги оногдуулах: Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн өдрийн 0.1 хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг уг хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн нь гэрээний үнийн 10 хувьтай тэнцэх дүнгээс хэтрэхүй. Дээд хэмжээнд хүрсэн тохиолдолд захиалагч нь гэрээг цуцлах тухай асуудлыг хөндөж болно.
10. Авлига, залилан мэхлэх үйл ажиллагаа: Дэлхийн банк нь энэ Гэрээний Хуваарь № А-д заасан авлига, залилан мэхлэх үйл ажиллагааны талаарх бодлогыг чанд мөрдөхийг шаардана. Нийлүүлэгч болон түүний туслан гүйцэтгэгчид, зөвлөхүүд нь Дэлхийн банкнаас томилогдсон этгээдээр гэрээний гүйцэтгэл, тендер шалгаруулалттай холбоотой данс, бүртгэлийг шалгуулах, Дэлхийн банкны томилсон аудитораар аудитлуулахыг зөвшөөрнө. Нийлүүлэгч болон түүний туслан гүйцэтгэгчид, зөвлөхүүд нь Дэлхийн банкны хяналт шалгалт болон аудитын эрхийг хэрэгжүүлэхэд саад учруулах тохиолдолд байгуулсан гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.
11. Нууцлал: Нийлүүлэгч нь Гэрээний болон Гэрээ дуусгавар болсноос хойш 3 жилийн хугацаанд Ажил үйлчилгээнд холбогдох нууцын зэрэглэлтэй болон оюуны өмчийн шинжтэй мэдээлэл, Захиалагчийн үйл ажиллагааг Захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрснөөс бусад тохиолдолд бусдад задлахгүй.
12. Өмчлөл: Гэрээний дагуу Нийлүүлэгчийн Захиалагчид зориулан бэлтгэсэн тайлан, судалгаа, програм хангамж, видео архивын материал болон бусад зүйл нь Захиалагчийн өмч болно. Нийлүүлэгч нь эдгээр баримт бичиг, программ хангамжийн хувийг өөр дээрээ хадгалж болно.
13. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх: Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглах явцад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн тохиолдолд гомдлыг нийлүүлэгч барагдуулж холбогдон гарах зардлыг хариуцна.
14. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал: Ийм нөхцөл байдал үүссэний улмаас Нийлүүлэгчийн хэрэгжүүлж чадаагүй үүргийн гүйцэтгэлд алданги оногдуулахгүй, түүний улмаас нийлүүлэгчийн гэрээг цуцлахгүй.

Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал гэдэгт Нийлүүлэгчийн хяналтаас гадуур, урьдчилан тооцох боломжгүй, гэхдээ Нийлүүлэгчийн анхаарал халамжгүй байдлаас үүссэгүй нөхцөл байдлыг ойлгоно. Энэ нөхцөл байдалд дараах орж болно: дайн, иргэний бослого, гал түймэр, үер, цар тахал, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг

Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд Нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар Захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр

зааварлаагүй бол Нийлүүлэгч нь гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.

15. Гэрээний үүргийг шилжүүлэх: Ямар ч тохиолдолд гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

16. Гэрээг цуцлах: Энэ зүйлийн 12.1-12.5 заалтад дурдсан нөхцөл байдлын аль нэг тохиолдвол Захиалагч нь доод тал нь ажлын 10 хоногийн хугацаатай мэдэгдэл бичгээр Зөвлөхөд өгснөөр Гэрээг цуцалж болно:

16.1. Нийлүүлэгч нь мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын долоон (7) хоногийн дотор, эсхүл захиалагчийн бичгээр сунгасан хугацаанд багтан доголдлыг арилган гэрээнд нийцүүлээгүй бол;

16.2. Нийлүүлэгч дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон бол;

16.3. Захиалагчийн эсхүл Дэлхийн банкны үзэж буйгаар Нийлүүлэгч нь гэрээнд өрсөлдөх, гэрээг хэрэгжүүлэхдээ /Банкны тухайн үед баримталж буй баримт бичиг заасан тайлбараар/ авлига, хээл хахууль, хууран мэхлэх, үгсэн хуйвалдах, заналхийлэх, саад тотгор учруулах үйл ажиллагаанд холбогдсон бол;

16.4. Нийлүүлэгчийн ирүүлсэн бараа нь техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй;

16.5. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүсээд 90 хоног үргэлжилвэл, энэ нь гэрээг цуцлах үндэслэл болно.

## Хуваарь № А: Авлигатай тэмцэх журам

### Авлигатай тэмцэх журам

(Энэхүү хавсралтад заасныг тендерийн баримт бичиг гэрээний нөхцөлд өөрчлөхгүйгээр тусгана)

#### 1. Зорилго

1.1 Дэлхийн банк (цаашид Банк гэх)-ны Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилт бүхий худалдан авах ажиллагаанд Дэлхийн банкны Авлигатай тэмцэх журам болон энэхүү хавсралтыг мөрдөнө.

#### 2. Шаардлага

2.1 Банк нь зээлдэгч (Банкны санхүүжилтээс үр шим хүртэгчдийг оролцуулан); тендерт оролцогч, зөвлөх, гүйцэтгэгч болон нийлүүлэгч; аливаа туслан гүйцэтгэгч, дэд зөвлөхүүд, үйлчилгээ үзүүлэгч эсхүл нийлүүлэгч, аливаа төлөөлөгч этгээд (мэдүүлсэн эсэхээс хамааран); тэдгээрийн аливаа мэргэжилтнийг Банкны санхүүжилт бүхий гэрээний худалдан авах ажиллагааны туршид сонгон шалгаруулалтад оролцох, гэрээ хэрэгжүүлэхдээ ёс зүйн өндөр стандартыг ханган ажиллах, залилан мэхлэх, авлигын үйлдлээс ангид байхыг шаардана.

2.2 Энэ хүрээнд Банк нь:

- (а) Дараах нэр томъёог дор өгөгдсөн утгаар тусгасан болно. Үүнд:
- i. “Авлигын үйлдэл” гэж нөгөө талын этгээдийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөхийн тулд аливаа үнэ бүхий зүйлийг шууд болон шууд бус хэлбэрээр өгөхийг санал болгох, өгөх, хүлээн авах, өгөхийг шаардахыг хэлнэ;
  - ii. “Залилан мэхлэх үйлдэл” гэж аль нэг тал хүлээсэн үүргээсээ зайлсхийх эсхүл санхүүгийн болон бусад ашиг олохын тулд санаатай болон санаандгүйгээр төөрөгдүүлэх, төөрөгдүүлэхийг оролдох аливаа үйлдэл, эс үйлдэхүй хийгээд дээрх зорилгоор хийгдсэн зөрүүтэй тайлбарыг хэлнэ;
  - iii. “Үгсэн хуйвалдах үйлдэл” гэж нөгөө талын этгээдийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх зэрэг байдлаар хууль бус зорилгод хүрэхийн тулд хоёр буюу түүнээс дээш талууд хамтран далд тохиролцох ажиллагааг хэлнэ;
  - iv. “Тулган шаардах үйлдэх” гэж нөгөө талын этгээдийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх, эсхүл хэн нэгэн этгээд эсхүл түүний өмчид шууд болон шууд бусаар хохирол учруулах, хохирол учруулахаар заналхийлэхийг хэлнэ.
  - v. “Саад учруулах үйлдэл” гэж
    - (а) Хяналт шалгалтын нотолгооны материалыг зориудаар устгах, хуурамчаар үйлдэх, өөрчлөх, нуун дарагдуулах, эсхүл авлига, залилан мэхлэх, нууцаар үгсэн хуйвалдах, албадан шахах буюу тулган шаардах үйлдлийг тогтоохоор Банкнаас хэрэгжүүлж буй хянан шалгах ажиллагаанд зориудаар саад учруулах зорилгоор асуудлыг шалгаж байгаа мөрдөгчид худал мэдүүлэх; эсхүл тухайн хянан шалгах ажиллагаатай холбогдох мэдээллийг мэдэж буй хүн өөрийг нь илчлэхээс сэргийлж айлган сүрдүүлэх, дарамтлах, заналхийлэх, мөн шалгалтын дараа гарсан шийдвэрийг дагаж мөрдөхөөс татгалзах зэрэг үйлдэл,
    - (б) Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийн зээлдэгчдэд зориулсан Худалдан авах ажиллагааны журмын Хавсралт 4-ийн 2.2 е-д заасны дагуу Банкны зүгээс хянан шалгах болон аудитын

эрхээ хэрэгжүүлэхэд нь ноцтой саад учруулахаар завдах үйлдлийг хэлнэ.

(b) Хэрэв гэрээ байгуулах эрх олгогдсон зөвлөх хуулийн этгээд эсхүл хувь хүн, түүний аливаа ажилтан, төлөөлөгч байгууллага, туслан гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгч, нийлүүлэгч болон тэдгээрийн ажилтнууд нь уг гэрээг авах зорилгоор өрсөлдөхдөө авлига, залилан мэхлэх, нууц үгсэн хуйвалдах, албадан шахах, эсхүл зориудаар саад учруулах үйлдэлд шууд болон шууд бусаар оролцсоныг Банк илрүүлсэн бол уг гэрээ байгуулах эрхийг цуцална;

(c) Холбогдох зээлийн гэрээнд заасан зөрчил арилгах арга хэмжээнээс гадна хэрэв Зээлдэгчийн төлөөлөл эсхүл зээлийн тодорхой хэсгээс хүртэгч этгээд нь тухайн гэрээний худалдан авах ажиллагаа, сонгон шалгаруулалт болон гэрээний хэрэгжилтийн явцад авлига, залилан мэхлэх, нууцаар үгсэн хуйвалдах, тулган шаардах, эсхүл зориудаар саад учруулах үйлдэл гаргасныг Банк олж тогтоосон бөгөөд энэ үед Зээлдэгчийн зүгээс эдгээр зөрчил бүхий үйлдлийн талаар мэдсэн даруйдаа Банканд мэдээлээгүй, мөн Банкны шаардлагад нийцэхүйц байдлаар цаг алдалгүй засаж залруулахаар зохих арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй тохиолдолд уг худалдан авах ажиллагааг амжилтгүй гэж зарлан цуцалж болно;

(d) Банкны Авлигатай тэмцэх журмыг баримтлан, Банкнаас авч хэрэгжүүлэх хориг арга хэмжээний талаарх бодлого, журамд заасны дагуу хуулийн этгээд эсхүл хувь хүнийг тухайн заасан хугацааны туршид (i) Банкны санхүүжилт бүхий гэрээ хэрэгжүүлэх эрх авах эсхүл санхүүгийн болон бусад хэлбэрээр ашиг шим хүртэх<sup>2</sup>; (ii) Банкны санхүүжилт бүхий гэрээ байгуулах эрх авсан эрх бүхий хуулийн этгээдийн туслан гүйцэтгэгч, зөвлөх, үйлдвэрлэгч болон нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчээр ажиллахаар нэр нь дэвших<sup>3</sup>; (iii) Банкны зээлийн аливаа хөрөнгөөс хүлээн авах эсхүл Банкны санхүүжилт бүхий төслийн бэлтгэл болон хэрэгжүүлэх шатанд оролцохыг нь хориглон, эрх бүхий бус этгээд гэж нийтэд зарлан мэдээлж болно;

(e) Банкны зээлийн санхүүжилт бүхий гэрээний болон тендерийн/санал авах баримт бичигт (i) тендерт оролцогч, зөвлөх, гүйцэтгэгч, нийлүүлэгч болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч, дэд зөвлөх, үйлчилгээ үзүүлэгч, нийлүүлэгч болон төлөөлөгч этгээдийн хувьд бүх данс, бүртгэл тооцоо, тендер ирүүлэх болон гэрээ хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад бичиг баримтад Банкнаас хяналт шалгалт хийх<sup>4</sup>, мөн эдгээр мэдээллийг Банкнаас томилсон аудитораар хянуулахыг зөвшөөрөх тухай заалтыг тусгасан байхыг шаардана.

<sup>2</sup> Эргэлзээ үүсгэхгүйн үүднээс хориг арга хэмжээ авагдсан талын гэрээ хэрэгжүүлэх эрх бүхий бус байдалд (i) урьдчилсан сонголт оролцох, зөвлөх үйлчилгээнд сонирхлоо илэрхийлэх, тендер шалгаруулалтад шууд оролцох болон тухайн гэрээний хувьд туслан гүйцэтгэгч, зөвлөх, үйлдвэрлэгч болон нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчээр нэр нь дэвших, мөн (ii) одоо хэрэгжиж буй гэрээний нэмэлт өөрчлөлтийн хүрээнд орж ажиллахыг хориглох нөхцөл хамаарах ба мөн үүгээр үл хязгаарлагдана.

<sup>3</sup> Туслан гүйцэтгэгч, зөвлөх, үйлдвэрлэгч болон нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчээр нэр нь дэвшсэн этгээд (тухайн тендерийн баримт бичгийн төрлөөс хамааран ялгаатай нэрлэдэг) гэдэгт (i) тендерт оролцогчийн хувьд урьдчилсан сонголт эсхүл тендер шалгаруулалтад оролцоход нь шаардагдах чадварын шаардлагыг хангахад дэмжлэг болох чухал ач холбогдол бүхий онцгой туршлагатай, ноу хауг эзэмшсэн этгээд байх; эсхүл (ii) зээлдэгчийн томилсон этгээд байна.

<sup>4</sup> Энд заасан хяналт шалгалт нь мөрдөн байцаах (жишээ нь шүүхийн) шинж чанартай байна. Эдгээрт залилан мэхлэх ба авлигын үйлдлийг тогтоохын тулд зохих механизмуудаар дамжуулан мөрдөн байцаалт/аудитын асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Банкнаас хийж байгаа эсвэл Банкны томилсон төлөөлөгчөөр хийлгэж байгаа тусгай ажиллагаа орно. Үүнд дараах үйл ажиллагаа багтах бөгөөд мөн эдгээрээр хязгаарлагдахгүй болно. Тухайлбал: Хуулийн этгээд, хувь хүний санхүүгийн бүртгэл тооцоо, холбогдох мэдээллийг авч шалгах, шаардлагатай бол тэдгээрийн хуулбарыг хийх; мөрдөн байцаалт/аудитад холбоотой хэмээн тооцогдож буй бусад бичиг баримт, дата мэдээлэл (цаасан болон цахим хувилбараар), ажилтнууд болон бусад холбогдох хүмүүсээс ярилцлага авах; бодит мөрдөн байцаалтыг хийх, хэрэг болсон газарт очин биечлэн үзлэг хийх, мэдээллийг баталгаажуулах гуравдагч талын туслалцааг авах зэрэг болно.

### Гүйцэтгэлийн баталгааны маягт (Банкны)

Баталгаа хүлээн авагч: *[Захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]*

Огноо: *[баталгаа гаргасан огноог бичих]*

Дугаар: *[баталгааны дугаар бичих]*

Баталгаа гаргагч: *[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч байгууллагын нэр, хаягийг бичих]*

1. *[Нийлүүлэгчийн нэрийг бичих]* (цаашид “Нийлүүлэгч” гэх) нь *[бараа үйлчилгээний товч тодорхойлолт]*-ыг нийлүүлэх зорилгоор *[Гэрээний нэр ба дугаарыг бичих]* (цаашид “гэрээ” гэх)-ыг Баталгаа хүлээн авагчтай байгуулсан тухай мэдээллийг ирүүлээд байна.
2. Нийлүүлэгчийн хүсэлтээр Баталгаа гаргагч нь Баталгаа хүлээн авагчийн өмнө нийт *[мөнгөн дүн]*-ийн төлбөрийн үүрэг хүлээж *[баталгааны дүн тоогоор]* *[дүн үсгээр]* баталгаа гаргаж байна.
3. Нийлүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай дурдаж төлбөр төлүүлэх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд Баталгаа гаргагч нь төлбөрийг тус мэдэгдэлд заасан дансанд үл маргах журмаар шилжүүлнэ.
4. Баталгаа гаргагчаас төлүүлэх шаардлагын хэмжээ нь энэ баталгааны 2-т заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба энэ хүрээнд захиалагчийн шаардсан аливаа мөнгөн дүнд ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.
5. Энэхүү баталгаа нь захиалагчийн дараах мэдэгдлийг ирүүлэх хүртэлх хугацаанд хүчинтэй байна: гэрээний үүргийг бүрэн гүйцэтгэж дууссаныг захиалагч хүлээн зөвшөөрсөн.
6. Энэхүү баталгааг хүчингүй болгоход зөвхөн захиалагчийн зөвшөөрлийг үндэслэх ба бусад үндэслэлээр хүчингүй болгосноос үүдэн гарах эрсдэлийг баталгаа гаргагч этгээд хариуцна.

#### Баталгаа гаргасан,

Банкны эрх бүхий албан тушаалтны нэр:

Албан тушаалын нэр:

Албан тушаалтны гарын үсэг:

Байгууллагын тамга, тэмдэг

Огноо:

Хаяг: